



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарив сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/020/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Алтай хот	Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
2026 он	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
	Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Цэрэнханд
	Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Б.Цэвэлмаа
	Утас: 99026016 Цахим хаяг: tsevelmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХНСС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13.
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.25 № 153

танай _____ -ны № _____ -т

ДАРИВ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дарив сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Хөрөнгийн орлого 14.4 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 13.1 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 3.7 сая төгрөгөөр, торгуулийн орлого 2.9 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2.1 сая төгрөгөөр, шууд бус орлого 1.3 сая төгрөгөөр, нийт 37.5 сая төгрөгийн орлого тасарсан,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөнөөс бэлэг дурсгал, шагналд 13.3 сая төгрөгийг зарцуулсан,

822511000149

- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 229.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.3, 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Дарив сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолын заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 398.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 542.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 143.5 сая төгрөгөөр буюу 36.0 хувиар давуулан биелүүлжээ.

Дарив дулаан ОНӨААТҮГ нь 2023 онд хувьчлагдсан боловч санхүүгийн тайланд 99.4 сая төгрөгийн өр төлбөртэй шалтгаанаар дуусгалын баланс гараагүй Дарив сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгдэж байна.

Аудитын гол асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Тайлант оны өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 251.3 сая төгрөгийн 44.0 хувь буюу 109.5 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын түлш шатахуун, гэрэл цахилгааны тогтмол зардлын, 40.0 хувь буюу 99.5 сая төгрөг нь Дарив дулаан ОНӨААТҮГ-ын, 8.0 хувь буюу 21.0 сая төгрөг нь Байгаль хамгаалах нөхөн сэргээх сангийн барьцаа хөрөнгийн, 8.0 хувь буюу 21.3 сая төгрөг нь ИТХ-ын цалингийн өглөг байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 8 хөтөлбөр, зорилтын 201 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 81.4 хувьтай үнэлжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	842,169.1	1,078,578.4
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	274,125.3	401,647.0
3	АВЛАГА	173,426.2	235,474.3
4	БАРАА МАТЕРИАЛ	317,928.6	338,318.1
5	НӨӨЦИЙН БАРАА	36,645.0	24,459.0
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	40,044.0	78,680.0
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,779,737.9	1,857,535.7
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,779,737.9	1,857,535.7
9	Биет хөрөнгө	1,558,415.1	1,623,832.9
10	Биет бус хөрөнгө	221,322.8	233,702.8
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,621,907.0	2,936,114.1
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	200,374.8	251,309.2
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	200,374.8	251,309.2
14	Өглөг	200,374.8	251,309.2
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,421,532.1	2,684,805.0
16	Засгийн газрын хувь оролцоо	2,421,532.1	2,684,805.0
17	Засгийн газрын оруулсан капитал	608,891.0	608,891.0
18	Хуримтлагдсан үр	1,601,754.0	1,865,026.8
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	210,887.2	210,887.2
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,621,907.0	2,936,114.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,956,033.0	1,941,472.7
2	ТАТВАРЫН ОРЛОГО	401,460.0	544,318.6
3	Орлогын албан татвар	342,133.8	382,854.0
4	Хувь хүний орлогын албан татвар	359,173.3	406,574.6
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(17,039.6)	(23,720.6)
6	Хөрөнгийн албан татвар	53,615.8	148,031.9
7	Бусад татвар, төлбөр, хураамж	5,710.4	13,432.8
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	539,016.4	1,397,154.1
9	Тусламжийн орлого	0.0	983,742.8
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,015,556.6	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,376,806.0	1,486,583.9
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,376,806.0	1,486,583.9
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,257,171.4	1,486,583.9
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	535,652.9	659,009.8
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,473.1	85,786.4
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385,054.3	431,720.5
17	Хангамж, бараа материалын зардал	24,926.3	24,444.8
18	Нормативт зардал	165.0	0.0
19	Эд хогшил, урсгал засварын зардал	10,241.9	300.0
20	Томилолт, зочны зардал	6,236.0	17,056.0

Дарив сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,328.6	18,193.6
22	Бараа үйлчилгээний бусад зардал	178,093.3	250,072.8
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,634.6	0.0
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	579,227.0	454,888.8
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	145,673.4	191,616.0
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(145,673.4)	(191,616.0)
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	433,553.6	263,272.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	2,007,648.8	2,007,648.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(19,670.3)	(19,670.3)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,987,978.6	1,987,978.6
4	Тайлант үеийн үр дүн	433,553.6	433,553.6
5	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	2,421,532.1	2,421,532.1
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,421,532.1	2,421,532.1
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,421,532.1	2,421,532.1
8	Тайлант үеийн үр дүн	263,272.8	263,272.8
9	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,684,805.0	2,684,805.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,512,947.8	1,718,338.9
2	ТАТВАРЫН ОРЛОГО	401,460.0	541,515.6
3	Орлогын албан татвар	342,133.8	382,854.0
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(17,039.6)	(23,720.6)
5	Хөрөнгийн албан татвар	53,615.8	145,228.9
6	Бусад татвар, төлбөр, хураамж	5,710.4	13,432.8
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,146.0	7,015.8
8	Газрын төлбөр	3,564.4	5,613.4
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	803.6
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,931.2	1,176,823.3
11	Нийтлэг татварын бус орлого	95,931.2	64,659.3
12	Тусламжийн орлого	-	973,892.3
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	138,271.8
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,015,556.6	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,176,874.2	1,265,472.9
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,176,874.2	1,265,472.9
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,057,239.6	1,265,472.9
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	541,110.1	661,803.4
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,417.0	91,834.8
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	347,050.1	376,121.9
21	Хангамж, бараа материалын зардал	21,673.8	31,232.1

Дарив сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

22	Нормативт зардал	429.8	-
23	Эд хогшил, урсгал засварын зардал	10,241.9	5,619.5
24	Томилолт, зочны зардал	6,236.0	17,056.0
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,264.7	18,988.6
26	Бараа үйлчилгээний бусад зардал	27,816.2	62,816.6
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,634.6	-
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	336,073.6	452,866.0
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	233,536.0	240,844.3
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	233,536.0	240,844.3
31	Дотоод эх үүсвэрээр	233,536.0	240,844.3
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(233,536.0)	(240,844.3)
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	84,500.0
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(84,500.0)
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	102,537.6	127,521.8
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	171,587.7	274,125.3
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	274,125.3	401,647.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,871,887.3	1,689,457.3	182,430.0	90.3
2	11	Татварын орлого	395,083.7	541,515.6	(146,431.9)	137.1
3	110	Орлогын албан татвар	298,607.6	382,853.9	(84,246.3)	128.2
4	1100	Хувь хүний орлогын албан татвар	322,328.3	406,574.6	(84,246.3)	126.1
5	110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	211,027.1	302,193.6	(91,166.5)	143.2
6	110002	Үйл ажиллагааны орлого	10,523.9	12,910.0	(2,386.1)	122.7
7	110003	Хөрөнгийн орлого	66,237.4	51,810.6	14,426.8	78.2
8	110004	Хөрөнгө борлуулсны орлого	-	6,404.6	(6,404.6)	
9	110008	Шууд бус орлого	34,539.9	33,255.8	1,284.1	96.3
10	1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(23,720.6)	(23,720.6)	-	100.0
11	110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	23,720.6	(23,720.6)	47,441.3	(100.0)
12	113	Хөрөнгийн албан татвар	78,898.6	145,228.9	(66,330.3)	184.1
13	113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	13,169.6	68.1	13,101.5	0.5
14	113002	Бууны албан татвар	2,820.0	4,445.5	(1,625.5)	157.6
15	113004	Малд ногдуулах албан татвар	62,909.0	140,715.3	(77,806.3)	223.7
16	118	Бусад татвар, төлбөр, хураамж	17,577.5	13,432.8	4,144.7	76.4
17	1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,367.5	7,015.8	(1,648.3)	130.7
18	118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,667.5	1,891.1	(223.6)	113.4

Дарив сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

19	118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,700.0	5,124.7	(1,424.7)	138.5
20	1181	Газрын төлбөр	7,700.0	5,613.4	2,086.6	72.9
21	118101	Газрын төлбөр	7,700.0	5,613.4	2,086.6	72.9
22	1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,510.0	803.6	3,706.4	17.8
23	118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	4,510.0	803.6	3,706.4	17.8
24	12	Татварын бус орлого	1,476,803.6	1,147,941.6	328,861.9	77.7
25	120	Нийтлэг татварын бус орлого	23,950.0	64,389.2	(40,439.2)	268.8
26	120003	Торгуулийн орлого	3,500.0	609.0	2,891.0	17.4
27	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	450.0	60,721.5	(60,271.5)	13493.7
28	120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	20,000.0	3,058.7	16,941.3	15.3
29	120009	Бусад орлого	-	-	-	
30	122	Тусламжийн орлого	945,280.6	945,280.6	-	100.0
31	122003	Аймаг нийслэлээс авсан татаас	945,280.6	945,280.6	-	100.0
32	122005	Төсвөөс санхүүжих	-	-	-	
33	123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	138,271.8	138,271.8	-	100.0
34	123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	138,271.8	138,271.8	-	100.0
		Оны эхний үлдэгдлээс	369,301.2	-	369,301.2	0.0
35	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,871,887.3	1,545,567.2	326,320.1	82.6
36	21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,272,405.2	1,235,592.9	36,812.3	97.1
37	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,272,255.2	1,235,592.9	36,662.3	97.1
38	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,295.4	661,803.4	6,492.0	99.0
39	210101	Үндсэн цалин	390,037.6	381,045.7	8,991.9	97.7
40	210102	Нэмэгдэл	267,757.3	271,829.0	(4,071.7)	101.5
41	210104	Урамшуулал	7,300.5	6,309.8	990.7	86.4
42	210105	Гэрээт ажлын хөлс	3,200.0	2,619.0	581.0	81.8
43	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,034.8	91,834.8	(1,800.0)	102.0
44	210201	Тэтгэврийн даатгал	64,224.9	65,319.6	(1,094.7)	101.7
45	210202	Тэтгэмжийн даатгал	6,902.2	6,902.2	-	100.0
46	210203	ҮОМШӨ-ний даатгал	3,451.1	3,451.1	-	100.0
47	210204	Ажилгүйдлийн даатгал	3,451.1	3,451.1	-	100.0
48	210205	Эрүүл мэндийн даатгал	12,005.5	12,710.8	(705.3)	105.9
49	2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	379,317.1	376,121.9	3,195.2	99.2
50	210301	Гэрэл, цахилгаан	18,082.2	18,541.6	(459.4)	102.5
51	210302	Түлш, халаалт	357,784.9	357,330.2	454.7	99.9
52	210303	Цэвэр, бохир ус	3,450.0	250.0	3,200.0	7.2
53	2104	Хангамж, бараа материалын зардал	22,207.4	19,232.1	2,975.4	86.6
54	210401	Бичиг хэрэг	3,558.0	2,503.3	1,054.7	70.4
55	210402	Тээвэр, шатахуун	12,200.0	12,095.7	104.3	99.1
56	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000.0	3,216.8	783.3	80.4
57	210404	Ном, хэвлэл	80.0	80.0	-	100.0
58	210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	80.0	60.0	20.0	75.0
59	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,289.4	1,276.3	1,013.1	55.7
60	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000.0	20,989.5	9,010.5	70.0

Дарив сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

61	210601	Багаж, техник, хэрэгсэл	17,000.0	15,370.0	1,630.0	90.4
62	210604	Урсгал засвар	13,000.0	5,619.5	7,380.5	43.2
63	2107	Томилолт, зочны зардал	14,349.8	17,056.0	(2,706.2)	118.9
64	210701	Гадаад албан томилолт	12,000.0	12,000.0	-	100.0
65	210702	Дотоод албан томилолт	2,349.8	5,056.0	(2,706.2)	215.2
66	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,550.0	6,036.9	5,513.1	52.3
67	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,500.0	2,923.5	2,576.5	53.2
68	210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700.0	403.2	296.8	57.6
69	210803	Даатгалын үйлчилгээ	500.0	-	500.0	0.0
70	210804	Тээврийн хэрэгслийн татвар	400.0	-	400.0	0.0
71	210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250.0	33.0	217.0	13.2
72	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,200.0	2,091.0	1,109.0	65.3
73	210807	Газрын төлбөр	1,000.0	586.2	413.8	58.6
74	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,500.7	42,518.3	13,982.4	75.3
75	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,667.1	39,014.7	12,652.4	75.5
76	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,833.6	3,503.6	1,330.0	72.5
77	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150.0	-	150.0	0.0
78	2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	
79	213103	Төсвийн санхүүжилт	-	-	-	
80	2132	Бусад урсгал шилжүүлэг	150.0	-	150.0	0.0
81	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150.0	-	150.0	0.0
82	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	499,482.1	225,474.3	274,007.8	45.1
83	223001	Бусад хөрөнгө	499,482.1	225,474.3	274,007.8	45.1
84	23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,000.0	84,500.0	15,500.0	84.5
85	230001	Эргэж төлөгдөх зээл	100,000.0	84,500.0	15,500.0	84.5
86	8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	143,890.1	(143,890.1)	
87	9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	143,890.1	(143,890.1)	
88	7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	143,890.1	(143,890.1)	
89	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	232,755.1	(232,755.1)	
90	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	376,645.2	(376,645.2)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	48,962,185.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,962,185.8
122	Тусламжийн орлого	48,962,185.8
1221	Хандив тусламж /дотоод/	48,962,185.8
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	48,962,185.8

350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,962,185.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,235,981.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,235,981.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,235,981.0
2104	Хангамж, бараа материалын зардал	12,000,000.0
210402	Тээвэр, шатахуун	12,000,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,937,681.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,937,681.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,298,300.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,298,300.0
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	3,726,204.8
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(3,726,204.8)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(3,726,204.8)

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллага, аудит хийсэн хэлбэр

Дарив сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 1 ОНӨААТҮГ, 4 байгууллагын (ЕБС, Соёлын төв, Цэцэрлэг, ЭМТ) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн, ИТХ, ХХС, БХНС, ОНХС, Соёлын төвийг санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хийж түүвэрт хамруулан, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаас тогтмол зардлыг аудитад хамруулсан.

Дарив дулаан ОНӨААТҮГ нь 2023 онд хувьчлагдсан боловч санхүүгийн тайланд 99.4 сая төгрөгийн өр төлбөртэй шалтгаанаар дуусгалтын тайлан гаргаагүй, Дарив сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгдэж байна.

3.1.2 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 45.5 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 24.5 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс 1 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 24.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.1.3 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 300.6 сая төгрөгийн 12 алдаа, мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой 709.9 сая төгрөгийн 4 алдааг залруулж, залруулагдаагүй нийт 205.4 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлснээс 15.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 126.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 63.0 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.2 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 43.9 сая төгрөгийн 1 алдааг¹ илрүүлж санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан (буруу ойлгосон), хайнга хандсан (мартсан, тэмдэглээгүй орхисон)

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд авлагыг 18.8 сая төгрөгөөр дутуу, өмнөх үеийн үр дүнг 25.1 сая төгрөгөөр бууруулж тайлагнасныг тус тус залруулав.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулагдаагүй нийт 50.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс их бөгөөд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 229.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 15.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 126.6 төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 87.4 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн тул шинж чанарыг харгалзан үзэж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 50.7 сая төгрөгийн 3 зөрчил² илрүүлснээс зөрчил арилгах 1 албан шаардлага, 50.7 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг хүргүүлсэн.

3.3 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 229.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 15.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 126.6 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 3 албан шаардлага, 87.4 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Батлагдсан төсөв, орлого, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Хөрөнгийн орлого 14.4 сая төгрөгөөр, шууд бус орлого 1.3 сая төгрөгөөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 13.1 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 2.1 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 3.7 сая төгрөгөөр, торгуулийн орлого 2.9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Дарив сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг үндэслэлтэй төлөвлөх, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах

2. Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлэг дурсгал, шагналд 13.2 сая төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасныг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Дарив сумын Засаг дарга	1	43,921.2			1	43,921.2	1	43,921.2	-	-	-	-
Дарив сумын ЗДТГ	1	45,542.7			1	45,542.7	1	45,542.7	-	-	-	-
Дарив сумын ИТХ	2				2	11,659.3	2	-	-	-	-	-
Дарив сумын ОНХС	9	303,230.3	1	150,224.1	8	153,006.2	9	303,230.3	-	-	-	-
Дарив сумын БХНСС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарив сумын ХХС	5	695,059.4	3	559,680.8	2	135,378.6	5	695,059.4	-	-	-	-
Дүн	18	1,087,753.6	4	709,904.9	14	389,508.0	18	1,087,753.6	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дарив сумын Засаг дарга	3	50,681.1	-	-	1	-	2	50,681.1	-	-	-	-
Дарив сумын ЗДТГ	4	24,463.0	-	-	-	-	3	24,463.0	1	1	-	-
Дарив сумын ИТХ	1	23,669.4	-	-	1	23,669.4	-	-	-	-	-	-
Дарив сумын ОНХС	5	165,897.4	-	-	2	102,942.4	3	62,955.0	-	-	-	-
Дарив сумын БХНСС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарив сумын ХХС	3	15,819.0	1	15,819.0	-	-	2	-	-	-	-	-
Дүн	16	280,529.9	1	15,819.0	4	126,611.8	10	138,099.1	1	1	-	-

4.3 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	Дарив сумын Засаг дарга	1	1	-	-	-	1	-	-
2	Дарив сумын ЗДТГ	1	1	-	-	1	-	-	-
3	Дарив сумын ИТХ	1	-	1	-	-	-	-	-
4	Дарив сумын ОНХС	1	-	1	-	-	-	-	-
5	Дарив сумын БХНСС	1	-	1	-	-	-	-	-
6	Дарив сумын ХХС	1	-	1	-	-	-	-	-
	Дүн	6	2	4	-	1	1	-	-